Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

# “БАЯНХУТАГ СУМЫН ЭМИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# Менежментийн захидал

**<u>Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:</u>**

Асуудал 1

Авлага, өглөгийн талаар ..................3

**2018 оны 03 дугаар 27 сар**

## Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Баянхутаг сумын ЭЭС-нд зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Баянхутаг сумын ЭЭС-ийн эрхлэгчид талархал илэрхийлье.

| Асуудал 1: Авлага, өглөгийн талаар | Тэргүүлэх ач холбогдол №1 |
|---|---|

***АГ-ын ажиглалт***

1. Санхүүгийн тайланд тусгагдсан 2712.9 мянган төгрөгийн өглөг, 2256.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6."Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***ААГ-ын зөвлөмж***

1. Санхүүгийн тайланд тусгагдсан өглөг, авлагыг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх

**Эрсдэлүүд**

Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулахгүй байх

**Төсвийн захирагчийн хариу**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**<u>ХЯНАСАН:</u>** ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

**<u>БЭЛТГЭСЭН:</u>** АХЛАХ АУДИТОР Б.НАРАНЦЭЦЭГ

2317144297
СЮА0046 9074082

БАЯНХУТАГ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
Н.ЗОРИГТБААТАР ТАНАА

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018-03-27 № 130

танай ______________ -ны № ______________ -т

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Баянхутаг сумын ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг хийхэд сумын ЗДТГ нь аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй.

### Санал дүгнэлт өгөхөөс татгалзах санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг үнэлж Баянхутаг сумын ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг бүрэн хийж, үнэн зөв бэлтгэсэн санхүүгийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 7-ныг хүртэл хүртэлх хугацаанд ирүүлээгүй тул санал дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхутаг сумын ЗДТГ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлт гаргахад суурилах аудитын хангалттай ба зохистой нотолгоог олж авах боломжгүй, санхүүгийн тайланд нөлөөлөхүйц аудитын нотлох зүйл байхгүй байна.

Бидний хийх аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг бүрэн хийгээгүй нь санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлэх боломжгүйд хүргэсэн.

### Аудитын гол асуудал

Баянхутаг сумын ЗДТГ 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 07-ныг хүртэлх хугацаанд ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-ийн "Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний

сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх " , Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн "Санхүүгийн бүртгэл, стандарт", НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн "Нягтлан бодох бүртгэл хөтлөх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Үүрэг, хариуцлага**

Баянхутаг сумын ЗДТГ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

БАЯНХУТАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Э.УНДРАХНАРАН ТАНАА

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018-03-24 № 137

танай ______________ -ны № ______________ -т

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Баянхутаг сумын ЭМТ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг хийхэд сумын ЭМТ нь аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй байна.

### Санал дүгнэлт өгөхөөс татгалзах санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг үнэлж Баянхутаг сумын ЭМТ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг бүрэн хийж, үнэн зөв бэлтгэсэн санхүүгийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 5-ныг хүртэл хүртэлх хугацаанд ирүүлээгүй тул санал дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхутаг сумын ЭМТ-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлт гаргахад суурилах аудитын хангалттай ба зохистой нотолгоог олж авах боломжгүй, санхүүгийн тайланд нөлөөлөхүйц аудитын нотлох зүйл байхгүй байна.

Бидний хийх аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг бүрэн хийгээгүй нь санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлэх боломжгүйд хүргэсэн.

### Аудитын гол асуудал

"Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх " , Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн "Санхүүгийн бүртгэл, стандарт", НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн "Нягтлан бодох бүртгэл хөтлөх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Үүрэг, хариуцлага**

Баянхутаг сумын ЭМТ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР